

ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ НЭР БҮХИЙ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТЫН ТАЙЛАН-2023 ОН

Төлөвлөгөөт хяналтын зорилго:

Төлөвлөгөөт хяналтын зорилго нь орон нутгийн “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид”-ийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлт, тус хорооноос батлан гаргасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагууд болон техник, стандартын хэрэгжилтийн байдлыг газар дээр нь шалгах илэрсэн зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах зэрэгт оршино.

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн А/47 тоот тушаалын хэрэгжилт:

Ажлын гүйцэтгэсэн хугацаа:

Хяналт, шалгалтын ажлыг 2023 оны 03-р сарын 13-ны өдрөөс 19-ний өдрүүдэд нийт 6 хоногт багтаан гүйцэтгэсэн.

Ажлын хэсгийн гишүүд:

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Машбат, Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ц.Ануужин, жолооч П.Мижиддорж нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид:

Төв аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч (ӨНТҮЭ) Төв Ньюс ХХК, Очир Арвай ХХК, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) Би Ти Жи ХХК, Өмнөговь аймагт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч, Ёл цуурай ХХК, Түвдэнгийн Бор ХХК, Говийн долгион мэдээллийн төв НҮТББ, Түвдэнгийн Бор ХХК-ийн “Миний говь” радио зэрэг үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна. Түүнчлэн Дундговь аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан Буянт чандмань сошиал медиа ХХК-ийн Маргад ТВ болон тусгай зөвшөөрөлгүй радио үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан.

Шалгалтад хамрагдсан байдал:

Уг шалгалтаар Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/47 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төв, Өмнөговь аймгийн “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид”-ийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тус хорооноос батлан гаргасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагууд болон техник,

стандартын хэрэгжилтийн байдлыг газар дээр нь шалгах илэрсэн зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэргийг хэрэгжүүлж ажилласан.

- *Телевизийн үйлчилгээ эрхлэгчид:* Шалгалтад хамрагдсан дийлэнх телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн бүтээл болон орон нутгийн бүтээл нь нөхцөл шаардлагад заасан хувь хэмжээнд хүрэхгүй, танин мэдэхүйн нэвтрүүлэг дамжуулсан цаг нь 90 цаг хүрэхгүй байгаа зэрэг нь “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ын 3.4, 3.6, 3.12.3 дахь заалтуудыг хангахгүй байсан. Мөн “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.3-т Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нэг блокийн үргэлжлэх хугацаа таван минутаас илүүгүй байна гэх заалт буюу блокийн хэтрэлт гаргасан байна. Түүнчлэн телевизийн сувгийн дууг EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах, техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлээгүй, эфирийн бичлэгийг архивлах техникийн боломжийг бүрдүүлээгүй зэрэг нь “Телевизийн үйлчилгээ эрхлэх нөхцөл шаардлага”-ын 3.1.8 болон 3.22.3 заалтуудыг хангахгүй байсан.
- *Радиогийн үйлчилгээ эрхлэгч:* Радиогоор нэвтрүүлж байгаа нэвтрүүлгүүд нь “Радиогийн хөтөлбөрт тавих шаардлага”-ыг бүрэн хангахгүй, өөрийн редакцын дүрэм, бодлого батлаагүй, редакцын зөвлөл байгуулаагүй, сонсогчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журамгүй байгаа зэрэг нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31.3.1, 31.3.2-т заасныг хангахгүй байсан. “Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.4, 3.12, 3.14, 3.16, 5.6, 5.7 дахь заалтуудыг хангах үүднээс захирлын тушаал гарган албажуулж, хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгаагүй байсан зэрэг зөрчил дутагдлыг арилгаж ажиллах талаар анхааруулга хүргүүлсэн.
- *Шалгалтаар олон сувгийн үйлчилгээ эрхлэгч* нь: Радио, телевизийн дууны түвшинг EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах, техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлээгүй, гамшгийн зарлан мэдээллийн системгүй, нөхцөл шаардлагад заасан дүрэм журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаагүй, Тасралтгүй ажиллагааны түвшний тайлан мэдээг хугацаанд нь ирүүлээгүй, байгууллагын цахим хаяггүй байгаа зэрэг нь “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.1.8, 3.1.10, 4.3, 4.8, 6.2, 6.12 дахь заалтуудыг хангахгүй байна. Мөн Дахин дамжуулж байгаа телевизийн сувгууд нь гадаад сувгийн хувь хэмжээ хэтэрсэн, сувгийн дарааллыг буруу байрлуулсан зэрэг нь “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-ын 2.3, 2.4 дэх заалтуудыг хангахгүй байсан.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гаргаж, зарим үйлчилгээ эрхлэгчдэд буюу үйл ажиллагаагаа нь тогтворгүй, мониторингийн дүнгээр хангалттай бус байгаа TBS телевиз, Говийн наран телевиз, Говь HD, Алтанговь зэрэг 4 телевиз, Миний говь радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд зөрчил тус бүрээр

хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелэлтийн тайланг нотлох баримтаар баталгаажуулан авахаар төлөвлөн ажилласан. Түүнчлэн 2023 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах Өмнөговь аймгийн Түвдэнгийн Бор ХХК-ийн Алтанговь телевиз, Миний говь радио, Төв аймгийн Төв нь юс ХХК-ийн ТBS телевизийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэн тусгай зөвшөөрлийн сунгахад харгалзан үзэх дүгнэлт гарган ажиллаж байна. ОСДҮЭ “Би ти жи” ХХК-ийн катв-д хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 04-р сарын 13-ны өдрийн А/111 тоот тушаалын хэрэгжилт:

Ажлын гүйцэтгэсэн хугацаа:

Шалгалтын ажлыг 2023 оны 04-р сарын 17-ноос 04-р сарын 23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Ажлын хэсгийн гишүүд:

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Машбат, Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ц.Ануужин, жолооч М.Сумъяа нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид:

Баянхонгор аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн 2 үйлчилгээ эрхлэгчид, Архангай аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч 2, ОСДҮЭ 1, Радиогийн 1 үйлчилгээ эрхлэгчид, Өвөрхангай аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч 1, ОСДҮЭ 2, Радиогийн 1 үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна. Өвөрхангай аймагт арилжааны радиогийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан Сайн цагийн залуус НҮТББ-ын “Сайн цагийн залуус FM-89.1” радио үйл ажиллагаагаа зогсоосон, хариуцсан эзэнгүй байсан.

Шалгалтад хамрагдсан байдал:

Уг шалгалтаар Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 04 дугаар сарын 13-ны өдрийн А/111 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид”-ийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд холбогдох хууль, тус хорооноос батлан гаргасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагууд болон техник, стандартын хэрэгжилтийн байдлыг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах талаар шаардлага тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтыг “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх тухай, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бэлтгэсэн байхыг урьдчилан мэдэгдсэн.

- Телевизийн үйлчилгээ эрхлэгчид:* Үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь өөрийн бүтээл болон орон нутгийн бүтээлийн дамжуулсан цаг нь нөхцөл, шаардлагад заасан хувь хэмжээнд хүрэхгүй, үндэсний түүх соёл, уламжлалын нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дамжуулсан хугацаа нь нөхцөл шаардлагад заасан хэмжээнд хүрэхээргүй, телевизээр нэвтрүүлэх гадаадын аль нэг кино тухайн улиралд нэвтрүүлэх нийт гадаадын киноны 50% хувиас хэтэрсэн байгаа зэрэг нь “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ын 3.4, 3.6, 3.12, 3.18 дахь заалтуудыг хангахгүй байсан. Мөн телевизийн сувгийн дууг EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах, техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлээгүй, эфирийн бичлэгийг архивлах техникийн боломжийг бүрдүүлээгүй зэрэг нь “Телевизийн үйлчилгээ эрхлэх нөхцөл шаардлага”-ын 3.1.8 болон 3.22.3 заалтуудыг хангахгүй байсан. Телевизээр нэг цаг тутамд дамжуулсан зар сурталчилгааны хувь хэмжээ хэтэрсэн, блокийн хэтрэлттэй, баннер байрлуулсан зэрэг дутагдлууд нь “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын 3.2, 3.3, 3.14 дахь заалтуудыг хангахгүй байсан.
- Радиогийн үйлчилгээ эрхлэгч:* Шалгалтаар 1 үйлчилгээ эрхлэгч нь үйл ажиллагаа эхлээгүй, радиогийн студи тохижуулах, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүний нөөцийн бүрдүүлэлтийн талаар ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байсан тул үйл ажиллагаа эхлүүлэх талаар дариу арга хэмжээ авч, энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэх, нотлох баримт ирүүлэх талаар сануулсан. Мөн 1 үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаагаа зогсоосон ба студи, радиогийн байранд хариуцсан эзэнгүй, шалгалт хийх нөхцөл боломжоор хангаагүй. Харин шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгч нь MNS 5591-1:2012 "Радиогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага"-ын телевизийн студийн зай талбай, удирдлагын өрөө зэрэг нь шаардлага хангахгүй байсан хэдий ч “Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.13.2-т заасан шаардлага хангахуйц тоног төхөөрөмжтэй байсан. Мөн тус шаардлагын 3.4, 3.12, 3.14, 3.16, 5.6, 5.7 дахь заалтуудыг хангах үүднээс захирлын тушаал гарган албажуулж, хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган үүрэгдүүлж өгөх тухай зөвлөснийг баримтжуулан ирүүлэхээр тогтсон.
- Олон сувгийн үйлчилгээ эрхлэгч:* “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллах талаар өөрийн техник, тоног төхөөрөмжийн нөөц боломжоор бүрдүүлсэн ч Харилцаа холбооны зохицуулах хороонд тасралтгүй ажиллагааны түвшний тайлан мэдээг маягтын дагуу ирүүлэхгүй байгаа нь тусгай зөвшөөрлийн НШ-ын 4.8 дахь заалтыг, байгууллагын цахим хаягтай болж шаардлагатай мэдээллүүдийг тусган, байнгын хөгжүүлэлт хийж, НШ-ын 6.2 дахь заалтыг хангаж ажиллаагүй. Мөн Радио, телевизийн дууны түвшинг EBU R128 зөвлөмжийн дагуу хянаж тохируулах техник, программ хангамжийг бүрдүүлээгүй нь НШ-н 3.1.8, 4.3 дахь заалтуудыг хангахгүй байна. Нөхцөл, шаардлагад тусгасан

дүрэм, журмыг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөөгүй, тоног төхөөрөмжийн холболтын кабель эмх цэгцгүй, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй, хэрэглэгчдийг гамшгийн үед зарлан мэдээлэх системээр хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлээгүй байгаа нь Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.1.10, 3.2.5, 3.5 дахь заалтуудыг хангахгүй байна. Ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээгүй байгаа нь Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.1.7, 3.2.6 дахь заалтуудыг хангахгүй байв.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах дүгнэлтэд харгалзахаар шалгалт хийх үеийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийн баримтжуулж, дэлгэрэнгүй тайлан боловсруулж, 2023 оны 5-р сарын Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч АБ телевиз, Тамир телевиз, Хас телевиз, Баянхонгор телевиз болон Номгон телевиз, АБ-ФМ, 89.5 радиогийн 1 үйлчилгээ эрхлэгчдэд хугацаатай үүрэг даалгавар, ОСДҮЭ 3, Ноён-Уул радио-д зөвлөмж, Сайн цагийн залуус радиод мэдэгдэл, ОСДҮЭ Эм эм ди эс ХХК, Гал саятан ХХК, Орхон системс ХХК-ийн катв-үүдэд дээрх зөрчил дутагдлыг арилгаж ажиллах талаар зөвлөмж, шаардлага хүргүүлж ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 05-р сарын 18-ны өдрийн А/149 тоот тушаалын хэрэгжилт:

Ажлын гүйцэтгэсэн хугацаа:

Тус хорооны эрх үүргийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтын төлөвлөгөөт ажлыг 2023 оны 05-р сарын 22-с 05-р сарын 26-ны өдрүүдэд нийт 5 хоногт багтаан гүйцэтгэсэн.

Ажлын хэсгийн гишүүд:

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Э.Золбаяр, Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Машбат, Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ц.Ануужин, радиогийн үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Уранбилэг, жолооч М.Сумьяа нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

Шалгалтад хамрагдсан байдал:

Улаанбаатар хотын алслагдсан Налайх дүүрэгт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч Буян налайх ХХК, ОСДҮЭ Эн Би Си ХХК, арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгч Буян налайх ХХК, Дорноговь аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч Ди медиа агентлаг ХХК, ОСДҮЭ Халиун кабель ХХК, арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгч Ди медиа агентлаг ХХК зэрэг үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна. Түүнчлэн Говьсүмбэр аймагт

ӨНТВ-ийн тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан. Төч смарт солюшн ХХК-ийн “Залуусын” телевиз, Давхар дэлгэц ХХК-ийн арилжааны радиогийн үйл ажиллагаа болон өөр зөвшөөрөлгүй радио, телевизийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан.

- *Телевизийн үйлчилгээ эрхлэгчид:* Телевизээр нэвтрүүлэх үндэсний бүтээл хувь хэмжээнд хүрээгүй, үндэсний түүх соёл, уламжлалын нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлгүүд шаардлага хангахгүй, аль нэг улсын кино нь тухайн телевизийн улиралд нэвтрүүлэх киноны 50 хувиас хэтэрсэн зараг нь “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ын 3.2, 3.12, 3.18 дах заалтуудыг хангахгүй байна. Түүнчлэн телевизийн сувгийн дууг EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах, техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлээгүй, эфирийн бичлэгийг архивлах техникийн боломжийг бүрдүүлээгүй нь “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.1.8 болон 3.22.3 заалтуудыг хангахгүй байсан.
- *Радиогийн үйлчилгээ эрхлэгч:* Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид нь MNS 5591-1:2012 "Радиогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага"-ын радиогийн студийн зай талбай, удирдлагын өрөө зэрэг нь шаардлага хангахгүй байсан хэдий ч “Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.13.2-т заасан шаардлага хангахуйц тоног төхөөрөмжтэй байсан. Мөн тус шаардлагын 3.4, 3.12, 3.14, 3.16, 5.6, 5.7 дахь заалтуудыг хангах үүднээс захирлын тушаал гарган албажуулж, хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган үүрэгдүүлж өгөх тухай зөвлөснийг баримтжуулан ирүүлэхээр тогтсон.
- *Олон сувгийн үйлчилгээ эрхлэгч:* “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллах талаар өөрийн техник, тоног төхөөрөмжийн нөөц боломжоор бүрдүүлсэн ч Харилцаа холбооны зохицуулах хороонд тасралтгүй ажиллагааны түвшний тайлан мэдээг маягтын дагуу ирүүлэхгүй байгаа нь тусгай зөвшөөрлийн НШ-ын 4.8 дахь заалтыг, байгууллагын цахим хаяггүй байгаа нь НШ-ын 6.2 дахь заалтыг хангахгүй байсан. Мөн радио, телевизийн дууны түвшинг EBU R128 зөвлөмжийн дагуу хянаж тохируулах техник, программ хангамжийг бүрдүүлээгүй нь НШ-ын 3.1.8, 4.3 дахь заалтуудыг, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй, хэрэглэгчдийг гамшгийн үед зарлан мэдээлэх системээр хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлээгүй зэрэг нь Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.1.10, 3.5, 3.2.5 дахь заалтуудыг хангахгүй байсан. Нөхцөл, шаардлагад тусгасан дүрэм, журмыг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах мөн тоног төхөөрөмжийн холболтын кабел эмх цэгцгүй байсан.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид тус бүрээр дэлгэрэнгүй тайлан мэдээ боловсруулж, Даргын зөвлөлд танилцуулсан ба тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт хангалтгүй Ди медиа агентлаг ХХК-ийн DTV, Халиун катв зэрэг 2 үйлчилгээ эрхлэгчдэд хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлсэн байна.

**ОРОН НУТГИЙН НЭР БҮХИЙ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ
ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТЫН 2023 ОНЫ
ТАЙЛАН**

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 08-р сарын 15-ны өдрийн А/227 тоот тушаалын хэрэгжилт:

Ажлын зорилго:

Тус ажлын хэсэг нь Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгуудад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж байгаа зарим үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтэд үзлэг, хяналт хийж, үнэлэлт дүгнэлт гаргах, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл, заавар, өгч ажиллах зэрэгт оршино.

Ажлын гүйцэтгэсэн хугацаа:

Тус хорооны эрх үүргийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтын төлөвлөгөөт бус ажлыг 2023 оны 08-р сарын 21-нээс 05-р сарын 26-ны өдрүүдэд нийт 6 хоногт гүйцэтгэсэн.

Ажлын хэсгийн гишүүд:

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Э.Золбаяр, Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Машбат, Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ц.Ануужин, РДЗХГ-ын хөдөлгөөнт хяналтын инженер М.Энхзориг, жолооч М.Сумъяа нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

Хяналтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид:

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч иргэн М.Мөнхбаярын Од тв, ОСДҮЭ Мөнх саран чулуу ХХК, Ди Би Эс Си ХХК, арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгч МонБЗ продакшн ХХК, Орхон аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч Очир роуд ХХК, Бунадо ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, ОСДҮЭ Дархан ширхэнцэг ХХК, арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгч ЭРДЭНЭТ үйлдвэр ТӨҮГ, Хөвсгөл аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн Лха сүлдэн тэнгэр ХХК, Өсөх прогресс ХХК, ОСДҮЭ Наран гүрт ХХК, арилжааны радиогийн Хасүби медиа ХХК, иргэн Ц.Даваацогт нарын үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна. Түүнчлэн радио давтамжийн ашиглалтыг тодорхойлох зорилгоор аймгийн төвүүдэд радио давтамжийн 20 МГц – 6 ГГц-ийн хооронд зурвасын хэмжилт хийсэн.

Шалгалтад хамрагдсан байдал:

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/227 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймагт Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж буй зарим иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тус хорооноос батлан гаргасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагууд болон техник, стандартын хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, хөтөлбөрт тавих шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт, нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах тухай зөвлөгөө, сургалтыг үйлчилгээ эрхлэгч тус бүрд биечлэн зохион байгуулж ажилласан.

- *Телевизийн үйлчилгээ эрхлэгчид:* Телевизээр нэвтрүүлэх үндэсний бүтээл хувь хэмжээнд хүрээгүй, үндэсний түүх соёл, уламжлалын нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг шаардлага хангах хэмжээнд хүрэхгүй, аль нэг улсын кино нь тухайн телевизийн улиралд нэвтрүүлэх киноны 50 хувиас хэтэрсэн зэрэг нь “Телевизийн хөтөлбөрт тавих шаардлага”-ын 3.2, 3.12, 3.18 дах заалтуудыг хангахгүй байна. Түүнчлэн телевизийн сувгийн дууг EBU R128 зөвлөмжид заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах, техник, программ хангамжийн боломжийг бүрдүүлээгүй, эфирийн бичлэгийг архивлах техникийн боломжийг бүрдүүлээгүй нь “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3.1.8 болон 3.22.3 заалтуудыг хангахгүй байсан. Мөн тус шаардлагын 3.15-с 21 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, телевизийн үйлчилгээг найдвартай, тасралтгүй хүргэх техникийн нөхцөлийг бүрдүүлээгүй байгаа нь нөхцөл шаардлагын 3.22 дах заалтыг хангахгүй байсан.

Бунадо ХХК-ийн Тэнгэр тв, Лха сүлдэн тэнгэр ХХК-ийн Түмний тв зэрэг 2 телевизийн үйлчилгээ эрхлэгч нь ХХЗХ-нд тодорхой шалтгаанаар эфирээ зогсоох болсон талаар мэдэгдэлгүй буюу Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31.3.4 (радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хууль болон гэрээнд зааснаас бусад үндэслэлээр хөтөлбөрийг хэсэгчлэн болон бүрэн зогсоохгүй байх)-д заасныг зөрчсөн.

- *Радиоогийн үйлчилгээ эрхлэгч нь:* Радиогоор нэвтрүүлж байгаа хөтөлбөр нь “Радиоогийн хөтөлбөрт тавих шаардлага”-ыг хангаагүй, өөрийн редакцын дүрэм, бодлого батлаагүй, редакцын зөвлөл байгуулаагүй, сонсогчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журамгүй байгаа зэрэг нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31.3.1, 31.3.2-т заасныг хангахгүй байсан.
- *Олон сувгийн үйлчилгээ эрхлэгч нь:* “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллах талаар өөрийн техник, тоног төхөөрөмжийн нөөц боломжоор бүрдүүлсэн ч Харилцаа холбооны зохицуулах хороонд тасралтгүй ажиллагааны түвшний тайлан мэдээг маягтын дагуу ирүүлэхгүй байгаа нь тусгай зөвшөөрлийн НШ-ын 4.8 дахь заалтыг, байгууллагын цахим хаяггүй байгаа нь НШ-н 6.2 дахь заалтыг хангаагүй, радио, телевизийн дууны түвшинг EBU R128 зөвлөмжийн дагуу хянаж тохируулах

техник, программ хангамжийг бүрдүүлээгүй нь НШ-н 3.1.8, 4.3 дахь заалтуудыг, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй, хэрэглэгчдийг гамшгийн үед зарлан мэдээлэх системээр хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлээгүй байгаа нь Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.1.10, 3.5, 3.2.5 дахь заалтуудыг хангахгүй байна. Түүнчлэн ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээгүй байгаа нь Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.1.7, 3.2.6 дахь заалтуудыг хангахгүй байна. Нөхцөл, шаардлагад тусгасан дүрэм, журмыг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах мөн Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын хэрэгжилт хангалтгүй, тоног төхөөрөмжийн холболтын кабель эмх цэгцгүй байсан.

Үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гаргаж, зарим үйлчилгээ эрхлэгчдэд буюу үйл ажиллагааг нь тогтворгүй, эфирээ зогсоосон, мониторингийн дүнгээр хангалттай бус байгаа үйлчилгээ эрхлэгчдэд буюу Бунадо ХХК, иргэн М.Мөнхбаярын Од телевиз, Очирроуд ХХК, Лха сүлдэн тэнгэр ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өргөн нэвтрүүлгийн телевиз, МонБЗ продакшн ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, иргэн Ц.Даваацогт нарын арилжааны радио, Дархан ширхэнцэг ХХК, Мөнх саран чулуу ХХК-ийн ОСДҮ эрхлэгчдэд хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелэлтийн тайланг нотлох баримтаар баталгаажуулан авахаар төлөвлөн ажилласан. Тусгай зөвшөөрөл нь түдгэлзүүлэгдсэн байгаа “Түмний” телевизийн эфирийг нээлгэж заавар өгч ажилласан болно.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

Харилцаа холбооны зохицуулах хороо